# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/08/НА-СТА-ТЗШ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0808@gmail.com

Хаан Соёмбо Аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

3. Аудитын тайлан ........ 10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 10

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин ........ 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 11

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12

4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 13

4.1 Ерөнхий зүйл ........ 13

4.2 Материаллаг байдал ........ 13

4.1Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 13

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14

5. Аудитын илрүүлэлт ........ 14

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.17 № 01/75
танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ч.ХУНШАГАЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 198 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан хэлтсийн барилгыг 1,910,884.9 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна

**Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс нь дотоод хяналтын нэгж, ажилтангүй байгаа нь байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх нөхцөл бүрдүүлж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 124 хувиар биелүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **58,513,414.84** | **46,399,505.16** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **18,190,000.00** | **27,611,896.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **18,190,000.00** | **27,611,896.00** |
| **3121** | **Төгрөг** | **18,190,000.00** | **27,611,896.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,190,000.00 | 27,611,896.00 |
| **33** | **АВЛАГА** | **21,440,162.96** | **1,397,034.96** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 20,043,128.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | **1,397,034.96** | **1,397,034.96** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,397,034.96 | 1,397,034.96 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **18,883,251.88** | **17,390,574.20** |
| **354** | **Хангамжийн материал** | **18,883,251.88** | **17,390,574.20** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,465,591.88 | 5,419,920.20 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,935,276.00 | 10,970,654.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,482,384.00 | 1,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **343,918,630.86** | **2,190,943,373.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **343,918,630.86** | **2,190,943,373.05** |
| **392** | **Биет хөрөнгө** | **290,993,630.86** | **2,138,018,373.05** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,359,284.00 | 1,916,244,184.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,679,643.28 | -20,226,345.03 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 144,512,000.00 | 144,512,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -107,125,369.15 | -120,735,824.95 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 258,017,647.71 | 268,302,866.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -60,147,788.00 | -109,910,491.35 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 61,213,672.00 | 74,818,472.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,427,024.83 | -18,714,971.85 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,690,762.02 | 4,690,762.02 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -419,909.61 | -962,278.64 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **52,925,000.00** | **52,925,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 52,925,000.00 | 52,925,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **402,432,045.70** | **2,237,342,878.21** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **402,432,045.70** | **2,237,342,878.21** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **402,432,045.70** | **2,237,342,878.21** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 264,748,776.50 | 264,748,776.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 264,748,776.50 | 264,748,776.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **114,582,121.66** | **1,949,492,954.17** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 37,481,713.66 | 114,582,121.66 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 77,100,408.00 | 1,834,910,832.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 23,101,147.54 | 23,101,147.54 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **402,432,045.70** | **2,237,342,878.21** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,174,952,051.00** | **3,060,613,126.52** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **98,378,537.00** | **1,930,310,626.52** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **98,378,537.00** | **1,930,310,626.52** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 77,527,537.00 | 1,930,310,626.52 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 20,851,000.00 | 1,930,310,626.52 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 77,527,537.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,076,573,514.00** | **1,130,302,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 993,883,514.00 | 1,120,212,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 993,883,514.00 | 1,120,212,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **82,690,000.00** | **10,090,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,000,000.00 | 10,090,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,690,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,079,263,992.80** | **1,225,702,294.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,079,263,992.80** | **1,225,702,294.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,017,160,020.37** | **1,054,702,623.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **711,597,006.11** | **675,542,908.00** |
| 210101 | Үндсэн цалин | 446,498,438.11 | 447,419,013.00 |
| 210102 | Нэмэгдэл | 115,545,285.00 | 97,611,266.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 67,059,133.00 | 60,760,172.00 |
| 210104 | Урамшуулал | 82,494,150.00 | 69,752,457.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **91,151,067.30** | **85,904,905.15** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,323,366.33 | 61,539,771.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,163,860.24 | 6,402,503.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,536,208.00 | 4,937,202.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,282,265.01 | 1,184,128.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,845,367.72 | 11,841,299.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,116,100.00** | **70,311,371.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 794,343.00 | 3,563,602.47 |
| 210302 | Түлш, халаалт | 28,226,679.00 | 64,518,113.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 595,078.00 | 2,229,656.00 |
| 210304 | Байрны түрээс | 9,500,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,393,862.50** | **17,247,136.59** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,468,290.00 | 6,460,643.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,051,273.50 | 5,449,102.55 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,183,249.00 | 2,387,620.64 |
| 210404 | Ном, хэвлэл | 433,400.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 494,000.00 | 420,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,180,650.00 | 2,529,170.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 583,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **18,649,500.00** | **6,085,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,649,500.00 | 6,085,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **00.00** | **774,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 774,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,037,000.00** | **584,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,037,000.00 | 584,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж** | **47,079,903.78** | **104,692,945.60** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,297,187.66 | 103,341,158.32 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 304,400.00 | 255,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 154,436.00 | 152,936.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,750,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 158,775.00 | 158,775.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх | 15,105.12 | 20,276.28 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **85,135,580.68** | **93,560,056.33** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,553,920.00 | 5,809,879.38 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,581,660.68 | 87,750,176.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **62,103,972.43** | **170,999,670.53** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 36,143,386.00 | 35,979,716.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,181,550.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 29,879,714.00 | 27,223,716.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,082,122.00 | 8,756,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 25,960,586.43 | 135,019,954.53 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,960,586.43 | 135,019,954.53 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **95,688,058.20** | **1,834,910,832.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 18,587,650.20 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 18,587,650.20 | 00.00 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-18,587,650.20** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **77,100,408.00** | **1,834,910,832.51** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **264,748,776.50** | **23,261,063.14** | **37,321,798.06** | **325,331,637.70** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **264,748,776.50** | **23,261,063.14** | **37,321,798.06** | **325,331,637.70** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 77,100,408.00 | 77,100,408.00 |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **264,748,776.50** | **23,101,147.54** | **114,582,121.66** | **402,432,045.70** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **264,748,776.50** | **23,101,147.54** | **114,582,121.66** | **402,432,045.70** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,834,910,832.51 | 1,834,910,832.51 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **264,748,776.50** | **23,101,147.54** | **1,949,492,954.17** | **2,237,342,878.21** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,076,573,514.00** | **1,166,544,224.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **16,198,596.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **00.00** | **16,198,596.00** |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 16,198,596.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,076,573,514.00** | **1,150,345,628.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **993,883,514.00** | **1,120,212,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 993,883,514.00 | 1,120,212,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **82,690,000.00** | **30,133,128.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,000,000.00 | 10,090,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,690,000.00 | 20,043,128.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,005,011,842.00** | **1,143,517,528.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,005,011,842.00** | **1,143,517,528.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **922,864,741.57** | **972,517,857.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **711,597,006.11** | **691,741,504.00** |
| 210101 | Үндсэн цалин | 446,498,438.11 | 463,617,609.00 |
| 210102 | Нэмэгдэл | 115,545,285.00 | 97,611,266.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 67,059,133.00 | 60,760,172.00 |
| 210104 | Урамшуулал | 82,494,150.00 | 69,752,457.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **91,151,067.30** | **85,904,905.15** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,323,366.33 | 61,539,771.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,163,860.24 | 6,402,503.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,536,208.00 | 4,937,202.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,282,265.01 | 1,184,128.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,845,367.72 | 11,841,299.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,116,100.00** | **70,311,371.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 794,343.00 | 3,563,602.47 |
| 210302 | Түлш, халаалт | 28,226,679.00 | 64,518,113.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 595,078.00 | 2,229,656.00 |
| 210304 | Байрны түрээс | 9,500,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,772,769.50** | **14,649,579.19** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,757,770.00 | 4,141,570.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,530,350.50 | 3,966,718.55 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,183,249.00 | 2,387,620.64 |
| 210404 | Ном, хэвлэл | 433,400.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,051,900.00 | 420,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,816,100.00 | 3,733,070.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **00.00** | **1,227,128.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 437,628.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 15,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 774,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,037,000.00** | **584,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,037,000.00 | 584,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **47,870,798.66** | **104,672,669.32** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,103,187.66 | 103,341,158.32 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 304,400.00 | 255,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 154,436.00 | 152,936.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,750,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 158,775.00 | 158,775.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,320,000.00** | **3,426,700.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,320,000.00 | 3,426,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **82,147,100.43** | **170,999,670.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **36,143,386.00** | **35,979,716.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,181,550.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,879,714.00 | 27,223,716.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,082,122.00 | 8,756,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **46,003,714.43** | **135,019,954.53** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,003,714.43 | 135,019,954.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **71,561,672.00** | **23,026,696.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **53,371,672.00** | **13,604,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,371,672.00** | **13,604,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **53,371,672.00** | **13,604,800.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 53,371,672.00 | 13,604,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-53,371,672.00** | **-13,604,800.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **18,190,000.00** | **9,421,896.00** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **18,190,000.00** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **18,190,000.00** | **27,611,896.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,120,212,500.0 | 985,192,545.5 | 135,019,954.5 | 87.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,120,212,500.0 | 985,192,545.5 | 135,019,954.5 | 87.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,091,009,400.0 | 955,989,529.5 | 135,019,870.5 | 87.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 809,929,800.0 | 691,741,504.0 | 118,188,296.0 | 85.4 |
| 210101 | Үндсэн цалин | 476,750,000.0 | 463,617,609.0 | 13,132,391.0 | 97.2 |
| 210102 | Нэмэгдэл | 154,742,400.0 | 97,611,266.0 | 57,131,134.0 | 63.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 75,504,000.0 | 60,760,172.0 | 14,743,828.0 | 80.5 |
| 210104 | Урамшуулал | 102,933,400.0 | 69,752,457.0 | 33,180,943.0 | 67.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,241,200.0 | 85,904,905.2 | 15,336,294.9 | 84.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,844,000.0 | 61,539,771.6 | 7,304,228.5 | 89.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,099,300.0 | 6,402,503.1 | 1,696,796.9 | 79.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,479,400.0 | 4,937,202.3 | 1,542,197.7 | 76.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,619,900.0 | 1,184,129.0 | 435,771.1 | 73.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,198,600.0 | 11,841,299.2 | 4,357,300.8 | 73.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 70,520,000.0 | 70,311,371.8 | 208,628.2 | 99.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,600,000.0 | 3,563,602.5 | 36,397.5 | 99.0 |
| 210302 | Түлш, халаалт | 64,520,000.0 | 64,518,113.3 | 1,886.7 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,400,000.0 | 2,229,656.0 | 170,344.0 | 92.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,252,900.0 | 17,250,679.2 | 2,220.8 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,155,900.0 | 4,141,570.0 | 14,330.0 | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,974,000.0 | 3,966,718.6 | 7,281.5 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,193,800.0 | 2,387,620.6 | 806,179.4 | 74.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 521,200.0 | 420,600.0 | 100,600.0 | 80.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,408,000.0 | 6,334,170.0 | -926,170.0 | 117.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,793,200.0 | 1,793,200.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,793,200.0 | 1,793,200.0 | 00.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,856,100.0 | 584,000.0 | 1,272,100.0 | 31.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,856,100.0 | 584,000.0 | 1,272,100.0 | 31.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,989,500.0 | 84,977,169.3 | 12,330.7 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,656,400.0 | 83,645,658.3 | 10,741.7 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.0 | 720,000.0 | 00.0 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 255,800.0 | 255,800.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 154,500.0 | 152,936.0 | 1,564.0 | 99.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.0 | 44,000.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 158,800.0 | 158,775.0 | 25.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,426,700.0 | 3,426,700.0 | 00.0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,426,700.0 | 3,426,700.0 | 00.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,203,100.0 | 29,203,016.0 | 84.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,203,100.0 | 29,203,016.0 | 84.0 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,223,800.0 | 27,223,716.0 | 84.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,979,300.0 | 1,979,300.0 | 00.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,120,212,500.0 | 985,192,545.5 | 135,019,954.5 | 87.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,120,212,500.0 | 985,192,545.5 | 135,019,954.5 | 87.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,120,212,500.0 | 985,192,545.5 | 135,019,954.5 | 87.9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **36,909,828.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **36,909,828.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **30,133,128.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,437,628.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 437,628.00 |
| 210602 | Тавилга | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,695,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,695,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,776,700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,776,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,776,700.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 46,331,724.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,331,724.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 30,133,128.00 |
| 131106 | Бусад орлого | 16,198,596.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 9,421,896.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 18,190,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 27,611,896.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс нь “Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино.” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

1. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр хангаж зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
2. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
3. Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх
4. Төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх
5. Мэдээллийн технилогид суурилсан “Цахим татварын алба” болох

Татварын ерөнхий газраас 2022 оныг “ **Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх жил”** болгон зарласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна гэж дүгнэлээ.

Татварын хэлтэс нь дотоод хяналт шалгалтын нэгжгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Тус байгууллагад дотоод аудитыг Татварын ерөнхий газраас хяналт тавьж хэрэгжүүлдэг ба тайлант онд ерөнхий газраас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтэс 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/156 тушаалаар баталж мөрдсөн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,834,910.8 мянган төгрөгөөр буюу 556 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 18,190.00 | 27,611.90 | 9,421.90 |
| Авлага | 21,440.16 | 1,397.03 | -20,043.13 |
| Бараа материал | 18,883.25 | 17,390.57 | -1,492.7 |
| Биет хөрөнгө | 290,993.63 | 2,138,018.37 | 1,847,024.7 |
| Биет бус хөрөнгө | 52,925.00 | 52,925.00 | 00.0 |
| **Нийт хөрөнгө** | 402,432.05 | 2,237,342.88 | 1,834,910.8 |
| Хуримтлагдсан үр дүн | 114,582.12 | 1,949,492.95 | 1,834,910.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 402,432.05 | 2,237,342.88 | 1,834,910.8 |

Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 9,421.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 20,043.1 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн мөнгөөр татаас санхүүжилтийн авлага үүсгэсэн байсныг тайлант онд барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 9,421.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 1,847,024.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 13,604.2 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 198 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Татварын ерөнхий газрын захиалгаар барьсан хэлтсийн барилгыг 1,910,884.9 мянган төгрөгөөр орлого авч бүртгэсэн.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/2429 албан тоотоор Татварын ерөнхий газраас 10,285.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй авсан.

Хуримтлагдсан үр дүн данс 1,834,910.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 1,258,248.9 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж 2021 оны 217 тоот албан бичгээр Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 66,517.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 101,250.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,090,481.9 мянган төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,090,481.9 мянган төгрөгийг баталж, Татварын ерөнхий газраас 29,730.6 мянган төгрөгийн төсвийн зохицуулалт хийж 1,120,212.5 мянган төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,120,212.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 985,192.5 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 135,020.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70205** | **Татвар хураалт, орлого бүрдүүлэлт** | **1,120,212.5** | **985,192.5** | **135,020.0** | **87.9** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 1007,353.0 | 872,343.8 | 135,009.2 | 86.5 |
| 80219 | Харуул хамгаалалтын зардал | 21,898.7 | 21,888.0 | 10.7 | 99.9 |
| 80220 | Холбооны суваг ашигласны төлбөр | 61,757.7 | 61,757.7 | 0.0 | 100.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 29,203.1 | 29203.0 | 0.1 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны төвлөрүүлсэн авлага 20,043.1 мянган төгрөг, Мөрөн сумын Засаг даргын А/158 захирамжаар 10,000.0 мянган төгрөг, Ахмадын сан байгуулах тухай А/47 тушаалаар 16,198.6 мянган төгрөг, Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газраас нийтийн биеийн тамирын арга хэмжээний шагнал 90.0 мянган төгрөг, нийт 46,331.7 мянган төгрөгийн орлого хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Татварын хэлтсийн2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах болон дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг  Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитор Н.Бадамханд нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,079,264.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21,525.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 17,268.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.1Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор  байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээлээгүй болон хугацаа хоцроож оруулсан мэдээлэл байхгүй байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд орон нутгийн төсвийн орлого 22.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 28.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 6.1 тэрбум төгрөгөөр, улсын төсвийн орлого 5.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 7.0 тэрбум төгрөг төвлөрүүлж 1.1 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтыг үндэслэж шатахууны зарцуулалтыг тооцож олгох тухай хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 8600.0 | 3 | 8,600.0 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **8600.0** | **3** | **8,600.0** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

**5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах тухай болон байгууллагын дотоод хяналттай холбоотой 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй болно.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэлт тайлагналтай холбоотой

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Байгууллагын даргын шийдвэр нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулахаар гарсан боловч Багаж техник хэрэгслийн зардлаас 437.6 мянган төгрөг, тавилга эд хогшлын зардал 15.2 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 54.3 мянган төгрөг, нийт 507.1 мянган төгрөгөөр хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зүйлс бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааварчилгаатай нийцэхгүй байна.

1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>

Батлагдсан төсвийн зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

2.1 <u>Илрүүлэлт:</u>

Байгууллага дотоод хяналтын нэгжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.2 дах заалттай тус тус нийцэхгүй байна.

2.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.2 дах заалтын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулж, хяналт хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлыг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан | 1 | 507.1 | | | | | 1 | 507.1 | | | | |
| Дотоод хяналттай холбоотой | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 2 | 507.1 | | | | | 2 | 507.1 | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:
АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: 8/15
БАТАЛГААЖУУЛСАН:
ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Х.ДИЙМАА
ЧАНАРЫН ХЯНАЛТ, АХЛАХ АУДИТОР Н.БАДАМХАНД

ХААН СОЁМБО АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ШТК0364 6697798
9021091402